

2

ТАТВАРЫН ФИЛОСОФИ-ТАТВАР БА ТАТВАР НООГДУУЛАЛТЫН ТУХАЙ

Г.Алтанзаяа

Татвар хэмээх ойлголт нь олон зуун жилийн түүхтэй билээ. Татварын тухай ойлголт нь хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхэн үеүүдэд байсаар ирсэн, цаашид ч байх болно гэдэг нь тодорхой юм. Татвар чухам яг хэдийд бий болсон вэ? гэдэгт эрдэмтэд нэг ойлголтонд хүрч очоогүй байгаа нь уншиж судалсан зүйлүүдээс ажиглагдлаа. Ер нь төр үүсэхэд татвар үүссэн гэдэг ойлголт дийлэнх талдаа байдаг бол Орос Улсын 2000 онд хэвлэгдсэн Т.Ф.Юткинагын "Налоги и налогообложение" гэсэн сурах бичигт татвар бол төр үүсэх үеэс ч өмнө байсан гэдгийг дараах байдлаар тайлбарласан байна. "Хуваарилалтын үйл явцын шаардлага төрийн бодлоос үл шалтгаалан оршин байсан. Иймээс өртгийн мөнгөн хэлбэрийг дахин хуваарилахад байх төрийн оролцоог татвар оршин байхын уг шалтгаан хэмээн үзэх ёсгүй. Төр бол аж ахуйг зохицуулагч, эрх зүйн субъект бөгөөд хуваарилагдсан өртгийн мөнгөн элементүүдийг татварын болон бусад элементүүдэд оруулах үүрэг хүлээнэ. Татвар нь янз бүрийн нэртэйгээр төр үүсэхээс өмнө байсаар байсан. Харин төр үүссэнээр татварын тархай бутархай хэлбэрүүдийг системчлэн хуулийн үндэстэй болгосон ба татвар ноогдуулалтын агуулгын эхлэлийг тавьжээ." (стр. 36).

Хүн төрөлхтний соёл иргэншлийн эхэн үеийн гүн сэтгэгчид татварыг нийгэмд чухал шаардлагатай, ашигтай зүйл гэж тайлбарлаж байсан ба тэдний татварын ойлголт нь дайны олз, боолын хөдөлмөр, тахилга үйлдэх зэрэг балмад шинжтэй байсан ч нийгэм хөгжихийн хэрээр татварын хэлбэр нь аажмаар өөрчлөгдөж, орчин үеийн агуулгад шилжсээр байна.

Татвар нь философийн төдийгүй, эдийн засгийн ойлголт бөгөөд нийгмийн ахуйн элемент юм. Энэ ойлголтын шинж чанар, агуулга нь хувь хүний болон байгууллагын бүтээсэн баялагын зохих хэсгийг авч, төсөв хэмээх нийтийн санд төвлөрүүлэхтэй холбогдсон харилцаа ба нийгмийн ухамсарт илрэн гарч байгаа үзэгдэл, үйл явц, сэтгэлгээ болно.

Энэхүү ойлголтын утга агуулга нь эрт дээр үед ч байсан ба одоо ч утга нь өөрчлөгдөөгүй

хэвээр үлдсэн байна. Энэ утга агуулгын нийгэмд зайлшгүй чухал шаардлагатайг болон түүний ашигтай шинж чанарыг ойлгох, танин мэдэх нь бидний зорилт болно. Хүний нийгмийн хөгжлийн учир шалтгаан нь янз бүрийн хэлбэрээр илрэн гарах бөгөөд байгалийн аюул буюу гадны дайсны эсрэг сөрөн зогсох, хамтын хүчээр нийтийн зориулалттай дэд бүтцийг бий болгох, хөдөлмөрийн чадваргүй нийгмийн эмзэг хэсгээ тэтгэх зэрэг нийгмийн олон асуудлыг шийдвэрлэхэд хүч хөдөлмөрөө болон хөрөнгө баялагаа төвлөрүүлэхэд хүргэсэн нь татвар оршин байх анхны шалтгаан болсон гэж эрдэмтэд үздэг. Тэгэхлээр татвар нь нийгмийн хэрэгцээг хангах үйл явц бөгөөд татварын философийн агуулга, мөн чанарт үндэслэсэн эдийн засгийн онолын нэг чухал ойлголт болох татвар ногдуулалт (аргачлал)-аар хэрэгждэг.

Түүнчлэн татвар нь төрийн санг бүрдүүлэхдээ хууль тогтоомжийн журмаар хэрэгждэг тулд эрх зүйн харьцааны нэг хэлбэр болдог. Татвар гэсэн энэхүү философийн хийсвэр төсөөллөөс сонгодог онолчдын үүсгэсэн зарчмуудад үндэслэн татвар ногдуулалт, татварын эрх зүйн харилцаа гэсэн тодорхой хэлбэрүүд бий болж хэрэгждэг.

Татвар нь философийн төдийгүй эдийн засгийн ойлголт, нийгмийн ахуйн элемент, эрх зүйн харилцааны нэг хэлбэр болдогийнхоо хувьд тухайн улсын эдийн засгийн тодорхой орон зай, улс төрийн байгууламж, удирдлагын системийн сайн муу талыг нь тусган харуулж байдаг. Иймээс тухайн улсын татварын эрх зүйн харилцааны байдлаар нь нийгмийн хөгжлийн дүр төрхийг тодорхойлдог байна. Аливаа улс үндэстний татварын систем нь татвар ногдуулалтын шинжлэх ухааны онолын болон практикийн цогцолбор үндэслэлд түшиглэн хөгжинө. Энэ нь үндэсний татварын системийг төлөвшүүлэн тогтоох зарчмыг томъёолох, түүний зохион байгуулалт, эрх зүйн үндэс, аргачлал, арга зүй, эцсийн зорилго, зорилтыг тодорхойлох үйл явц юм.

Нийгмээс төртэйгээ, төрөөс нийгэмтэйгээ харьцах харьцааны энэхүү татварын хэлбэрийг янз бүрээр нэрлэдэг байна. Тухайлбал: Германд татварыг иргэдээс төр улсдаа үзүүлж байгаа дэмжлэг, Англид иргэний үүрэг, Францад заавал өгөх төлбөр, Оросод албадлагын төлбөр гэх зэргээр нэрлэдэг бол Монголд үндсэн хуулиндаа иргэний үүрэг болгон заасан ба татварын хуулиндаа заавал өгөх төлбөр гэсэн утгаар тодорхойлсон байгааг бид мэднэ. Орчин үеийн татварын агуулга нь нөөцийг хуваарилагч, эдийн засгийг зохицуулагч хөшүүрэг гэсэн утгаар их хэрэглэгдэх болж байна. Гэхдээ яаж нэрлэгдэх, хэрэглэгдэх нь ялгаагүй түүний дотоод агуулга өөрчлөгдөхгүй билээ.

Эдийн засгийн сэтгэлгээний сонгодог төлөөлөгчид XVI зууны тэртээгээс татвар ногдуулах зарчим, түүнийг тодорхойлох суурь ойлголтыг өөрсдийнхөө бүтээлүүдэд гаргажээ. Тухайлбал: Ф.Кенэ, А.Смит, Д.Рикардо нар татвар ногдуулалтын суурь зарчмуудыг тунхагласан татварын сонгодог онолын үндэслэлүүдийг тавьсан гэж эрдэмтэд үздэг. Анх суурь нь тавигдсан зарчмуудыг А. Смит улам тодорхой болгож, А. Вагнер улам боловсронгуй болгожээ. Чухам эдгээр зарчмууд л "татвар" хэмээх эдийн засгийн категорин дотоод нөөц боломжийг тодорхойлно. Энэ үеэс тэд татварыг нийгмийн үйлдвэрлэлийн салшгүй элемент, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл гэж үзжээ.

Татварын тухай сэтгэлгээний түүх, түүний өөрчлөлт хувьслыг дэлхийн эрдэмтдийн бүтээлүүдэд нэгэнт туссан сонгодог үзэл санаа нь шудрага ёс, тэгш байдал, уян хатан, ил тод байх, татварын удирдлагын үр нөлөөтэй байх зарчмыг хэрэгжүүлэхэд үндэслэсэн татвар ногдуулалт юм.

Дэлхий хоёр систем болон хуваагдаж хоорондоо зөрчилдөх хүртэл татвар бол эдийн засгийн урамшуулал, удирдлагын арга гэсэн үзэл баримтлал онолын шинжтэй логик сэтгэлгээнд хөгжиж байжээ. ЗХУ болон ЭЗХТЗ-ийн орнууд социализм байгуулах замд орохдоо А.Маршал,

Д.Милль, Э.Селегман үзэл санаанд тулгуурласан АНУ, Англи, Герман, Франц, Япон улсуудын хэрэгжүүлж байсан татварын системээс хазайсан байна. ЗХУ-ын эрдэмтэд татвар бол социализмын элемент биш харин капитализмын дотоод мөн чанар гэдгийг баталж байв. Тэд "Үйлдвэр худалдааны эзэдгүйгээр томоохон үйлдвэрлэл зохион байгуулахын тулд нэгдүгээрт нийгмийн аж ахуйн таваарын байгууллыг устгаж, түүнийг коммунист байгууллаар солих хэрэгтэй бөгөөд энэ нөхцөлд үйлдвэрлэлийг зохицуулагч нь зах зээл биш харин үйлдвэрлэгчид ажилчдын нийгэм өөрөө байх ба үйлдвэрлэлийн хэрэгсэл хувь хүмүүст биш нийт нийгэмд хамрах ёстой" гэсэн В.И.Лениний үзэл санааг баримталж байсан.¹ (стр. 17).

1921 оноос ЗХУ-ын тусламжтайгаар социализмын замыг сонгосон Монгол орны хувьд ч мөн адил дээрх үзэл бодлыг баримталж байсан учир татварыг санхүүгийн нөөцийг улсын санд дайчлах арга төдийгөөр хязгаарлаж байжээ. Иймээс энэ үеийн социалист нийгмийн эрдэмтэд татварыг санхүүгийн нөөцийг улсын санд дайчлах арга төдийгөөр судалгааны ажлаа ч хязгаарлаж байжээ.

Нийгэм, эдийн засагт чухал шаардлагатай элемент болохын хувьд татварын ойлголтонд философийн үүднээс гүн гүнзгий дүн шинжилгээ хийснээр татвар, татвар ногдуулалтын онолын үндэслэлд шинжлэх ухааны байр суурьнаас хандах болно.

Онол гэдэг нь философийн үүднээс авч үзвэл онолын хуулиудыг системчилсэн мэдлэгийн хэлбэр юм. Онол нь тухайн шинжлэх ухаанд байсан ба байгаа, байж болох бүх боломжийг агуулж байх ёстой байдаг. Дээрх ойлголтууд нь онолыг харьцангуй тогтвортой, илүү тодорхой мэдлэгийг агуулдаг мэдлэгийн тогтолцоо болохыг харуулж байна.

Философи нийгмийн шинжлэх ухааны судалгааны объектыг дараах өвөрмөц онцлогтой гэж үздэг. Үүнд:

1. Нийгэмд аливаа өөрчлөлтүүд их гардаг
2. Нийгэмд субъектив хүчин зүйлсийн нөлөөлөл их гардаг

Энэ үүднээс авч үзвэл судалгааны объект болох татвар, татвар ногдуулалт нь өөрчлөлт их гардаг, субъектив хүчин зүйлсийн нөлөөлөл ихтэй байдаг үндсэн шинжүүдийг агуулна. Нийгэм бол маш эрчимтэй олон талт үйл явцаар хөгждөг. Тэр дундаа практикт энэ олон талт үйл явцыг толь мэт харж онолтой холбох боломжгүй ч байж болно. Тухайн улсын хэмжээнд татварын онол, практикийг нэгтгэх үүргийг төрийн татварын бодлого гүйцэтгэнэ. Бодлогын хүрээнд үл шийдвэрлэгдэх баримтууд хуримтлагдаж асуудал үүснэ. Асуудал бол зайлшгүй шийдвэрлэх ёстой зөрчил юм. Философид асуудлыг шийдвэрлэхдээ онолыг өөрчлөх замаар эсвэл онолыг өргөжүүлэх замаар шийдвэрлэдэг гэж үздэг. Асуудал нь хуучин онолын хүрээнд шийдвэрлэгдэх боломжгүй бол өөрчлөх ба оршин байгаа онолын хүрээнд шийдвэрлэх боломжтой бол онолын өргөжүүлэлт явагдана. Гэвч онолыг өөрчлөх үү, өргөжүүлэх үү гэдэг нь тодорхойгүй байдалд ихэвчлэн үлддэг.

Монгол улс 1990 оноос хойш төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн удирлагаас татгалзаж зах зээлийн эдийн засагт шилжих чухал алхмуудыг хийсэн. Үүний нэг нь татварын өнөөгийн тогтолцоо бий болсон явдал юм. Монгол улсын хөгжлийн шинэ шатанд хуримтлагдаж буй шийдвэрлэвэл зохих асуудлууд нь төрийн цэгцтэй бодлого, хүчтэй зохицуулалт үгүйлэгдэж байна гэсэн үндэслэлийг дэвшүүлэхэд ч болох юм. Энэ нь мөн татварын тогтолцоонд ч хамрана. Онол практикийг хооронд нь ойртуулж чадах, онолд үндэслэсэн бөгөөд практикаар нотлогдсон татварын бодлогыг боловсруулах шаардлага тавигдаж буй нь тодорхой юм.

Цаасан дээр бичигдсэн онолыг бодлого болгон хувиргах нь тийм ч амархан зүйл биш бөгөөд

олон тооны зөрчилтэй асуудал гардаг байна. Гэхдээ онолгүй практик гэж байх ёсгүй. Онол гэдэг нь хүн төрөлхтний нийгмийн хөгжлийн явцад байнга дагалдаж байдаг үйл явц буюу үзэгдлийн язгуур үндэс, учир шалтгааныг тайлбарлаж, үүнийг хүний ахуйн хэрэгцээнд үр өгөөжтэй ашиглах боломж олгодог цогц үзэл санаа юм (стр. 20).

Татвар хэмээх ойлголтын шинжлэх ухааны бүх тодорхойлолтыг судласнаар татварын бодлогод баримтлах янз бүрийн бодлогын өвөрмөц байдлыг илрүүлэн гаргахад тустай юм. Гэвч судлаач "Татвар" хэмээх эдийн засгийн категориын агуулга, мөн чанарыг төрөөс явуулж байгаа бодлогын байр суурьнаас зөвхөн авч үзвэл жинхэнэ ёсоор нь гаргаж чадахгүй. Учир нь бодлого гэдэг нь өөрчлөмтгий, түүнийг төр засгийн эрх баригчид тодорхойлдог буюу аливаа улс оронд явуулж байгаа бодлого нь үндэсний цөөнхийн эрх ашигт үйлчилдэг гэдгийг түүх нотолно. Татварын онолын үүднээс бол тухайн нэг намын татварын бодлого гэж байхгүй бөгөөд тухайн улс орны эдийн засаг, улс төрийн давхаргад нийцсэн татварын бодлого нь дараагийн намын үед ч үргэлжлэн хэрэгжих учиртай. Гэвч төр засгийн эрх баригчид нь татварын бодлогод намын үзэл бодол нь шууд тусгадаг нь нууц биш юм. Өөрөөр хэлбэл төр засгийн бодлогоо хэрэгжүүлэх нэг механизм нь татвар болдог нь тодорхой. Иймээс нийгмийн нийт орлогын нэг хэсгийг улсын болгон авах хуулиар зөвшөөрөгдсөн татвар ногдуулалт нь эдийн засгийн төдийгүй нийгэм-улс төрийн категори юм. Нийгэм-улс төрийн хөгжлийн таатай нөхцөлд эдийн засгийн хөгжлийн түлхэгч хүч, зохицуулагч элемент болдог байна.

"Татвар" хэмээх ухагдахууныг олон янзаар тодорхойлох нь татварын системийн зохион байгуулалт, түүний бүрдэл хэсгүүдийн бүтэц, улс орны хөгжилд гүйцэтгэж буй үүрэг, зээл, мөнгө санхүүгийн бодлого зэрэг асуудлуудын эргэн тойронд маргаан үүсгэдэг ба энэ тодорхойлолт нь практикт ашиглаж буй түүний гаднах хэлбэрийн мөн чанарыг ихэвчлэн илэрхийлдэг. Эртний үед татварын мөн чанар, агуулгад дээд эрх баригчдын ашиг сонирхлыг тусган илэрхийлж байсан нь татвар бол нийгмийн амьдралын гарцаагүй бурангуй үзэгдэл хэмээх ойлголтыг бататгах үе байжээ. Татварыг зөвхөн харагдах хэлбэрийн байр суурьнаас тодорхойлон тайлбарлах нь татварын эрх зүйн харьцааны хүрээг өргөтгөн, нийгмийн хэрэглээний бодит боломжийг харгалзахгүйгээр улсын зардлын тухайн үеийн төвшинд нийцүүлэн хөөрөгдөн нэмдэг байна. Татварын ийнхүү тогтолцоо нь эдийн засгийн хөгжлийг саатуулж, татвар төлөгчдийн итгэл үнэмшлийг алдагдуулна. Иймээс "Татвар", "Татвар ногдуулалт" гэсэн ойлголтыг онол, практикийн үүднээс танин мэдэх явдал.

Татвар хэмээх ойлголтыг ертөнцийг үзэх үзлийн зүгээс авч үзвэл эдийн засгийн бодит категори болно. Иймээс татварыг судлах нь татвар ногдуулалт буюу эдийн засгийн бааз суурийн харилцан хамаарал, нөлөөллийг эрж хайхад хүргэнэ. Санхүүгийн онолын байр суурьнаас авч үзвэл татвар ногдуулалт нь өртөг бүрдүүлэх, нөөцийг хуваарилах ерөнхий хуулиудын шаардлагын дагуу хэрэгждэг нэг салбар нь юм.

Дээр дурьдсан бүхэн нь "Татвар", "Татвар ногдуулалт"-ыг цэвэр шинжлэх ухааны байр суурьнаас ялган авч үзэх хэрэгтэй гэдгийг баталж байна. Татварын хоёрдмол шинж чанарын тухай тайлбарлана гэдэг бол татвар ногдуулалтын бүх тогтолцоонд дүн шинжилгээ хийхэд зөв хандана гэсэн үг юм. Татвар нь нийтлэг ерөнхий категори бол татвар ногдуулалт нь эдийн засгийн тусгай категори юм. Татвар гэдэгт хувь хүний хөрөнгө буюу орлогыг нийгэмчлэх тухай нийгэмд болсон харьцааны дан ганц философийн утга оршино. Харин татвар ногдуулалт нь илүүдэл орлогыг нийгэмчлэх тэр шаардлагыг ургуулан бодох ба дахин хуваарилах харьцааны ерөнхий дүр төрхийг төсөөлнө.

Татварын мөн чанарыг тодорхойлбол:

- Татвар бол эдийн засгийн суурийн бодит байдлаас үндэслэн тогтоогддог ихэвчлэн мөнгөөр заавал төлөх төлбөр юм.

- Татвар нь үйлдвэрлэл ба шинэ техник, технологийн хөгжилтөнд саад болох ёсгүй.
- Татварт зохицуулах буюу хянан шалгах гэсэн үүрэг хослож, шингэсэн байдаг.
- Татварт орлого, үйл ажиллагааны төрөл, иргэд, байгууллага, салбар, нутаг дэвсгэрийн хэлбэрүүд бүгд хамрагдана.

Татварын энэхүү дотоод мөн чанарт үл нийцсэн хэлбэрийг сонгон авах нь татвар ногдуулалтыг хамгийн шилдгээр төсөөлөх гээд ч нэмэргүй. Учир нь категориын дотоод мөн чанар, түүний бодит байдалд илрэн гарах гадаад хэлбэр хоёр бол салахын аргагүй нэгдмэл юм. Тухайн хэлбэрийг сонгон авах арга, түүнийг бүтээгчдийн мэрэгжлийн ур чадвар, нийгмийн ухамсрын төлөвшсөн байдал, түүнийг практикт хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн байдал зэрэг нь агуулга, хэлбэрийн зөрчлийг үүсгэх шалтгаан болдог. Иймээс аливаа үйл явцын агуулга, түүнээс илрэн гарч байгаа шинж чанарыг танин мэдэх, зохицуулах үр ашигтай механизмууд шаардлагатай юм.

"Татвар", "Татвар ногдуулалт", "Татварын механизм" гэсэн ухагдахууны агуулга, мөн чанар, харилцан хамаарлыг ойлгоход тэдгээрийг "Оюутан", "Сургалт", "Боловсролын үйл явц" хэмээх ухагдахуунтай харьцуулах явдал тус болно.¹ (стр. 26). Энэ номондоо уг ойлголтын харьцуулалтыг хийхдээ: "Татвар бол эдийн засгийн категори, харин оюутан бол нийгмийн категори юм. Энэ хоёр категори нь хоёулаа өөрийн гэсэн дотоод нөөцтэй бөгөөд энэ нөөцөө өөртөө оногдсон үүргээ хэрэгжүүлэхэд ашиглана. Татвар нь төр ба татвар төлөгчийн хооронд үүссэн эдийн засгийн харилцааны зуучлагч болохын хувьд төр улсын орлогыг хангаж, эдийн засгийг нийтэд нь зохицуулах үүрэг гүйцэтгэх ёстой. Оюутан бол түүнд өгч байгаа мэдлэгийг эзэмшиж, түүнийг өөрийнхээ оюуны чадавхаар баяжуулж, практикт бүрэн дүүрэн хэрэгжүүлэх ёстой. Энэ бол оюутан хүний үүрэг. Аливаа категори онолын хувьд агуулагдсан нөөц хүч нь түүний практик хэлбэрт илрэн гардаг байна. Оюутан хүн угаасаа залхуу, удамшиж үлдсэн өргөн чадвартай биш гэж үзье. Харин сонгон авсан татварын хэлбэр нь тухайн эдийн засагт тохиромж муутай хэрэгжих боломжгүй гэж үзье. Тэгвэл засаж сайжруулж эдийн засгийн суурьт нийцсэн шинэ татварын хэлбэрийг эрж хайн солино. Харин оюутныг сурах чадвар сайтай шинэ оюутнаар солих болох нь. Гэхдээ татвар болон оюутан хэмээх категориын мөн чанар өөрчлөгдөхгүй, тэдгээрийн дотоод нөөц боломж, үүрэг хэвээр үлдэнэ. Харин шинэ татвар, шинэ оюутны гүйцэтгэх үүрэг л өөрчлөгдөнө. Гэхдээ эдгээр категориын нөөц боломжийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх явдал бодит ахуй болон ухамсраас шалтгаална. Оюутаны сурч буй сургууль нь сургалтын сайн баазгүй, багш нар нь мэдлэг чадвар муу, байнга солигддог бол оюутан өөрийн дотоод нөөц, хүчээ бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй. Хамгийн үр ашиг бүхий татварын хэлбэрийг сонгосон байсан ч хямралтай эдийн засаг, улс төрийн бодлого нь тогтворгүй нөхцөлд хэрэгжиж эхэлсэн бол мөн ийм л хувь заяа оногдоно. Тэгэхлээр категориын дотоод нөөц, боломжийг бүрэн дүүрэн илрүүлэн гаргахад нийгмийн ухамсрын байдал, төрөөс явуулж байгаа улс төрийн бодлого нөлөөлнө. Засгийн газарт нь байнга өөрчлөлт гарч, улс төрчид нь болон хууль тогтоогчдын олонх нь мэдлэг мэргэжил муутай, татварын албадыг өндөр мэргэжлийн боловсон хүчнээр хангаагүй, хууль тогтоомж нь тогтвортой бус, засаг төрийн дээд эрх баригчдын дотор зөрчилтэй байх зэрэг нь эдийн засгийн категори болох татварын өөрийнх нь дотоод нөөцийг хэрэгжүүлэх боломжгүй болгодог байна.) гэж тайлбарлажээ.

Эдийн засгийн аливаа категориын дотоод агуулга нь түүнийг үр ашигтай ажиллах дотоод нөөц боломжоо ашиглах чадвар, нийгмийн үйл явцад нөлөөлөх бодит боломж байх нь. Татварын агуулга нь улс орны төсвийн орлогыг бүрдүүлэх, эдийн засгийг тэнцвэржүүлэх боломж болно.

Хүний ухамсар эдийн засгийн үйл явдлын зүй тогтлуудыг зэрэгцүүлэн танин мэдэхийн тулд категориудыг бий болгодог байна. Категориуд нь системийг бий болгох буюу тухайн үйл

явцыг удирдах механизмаар дамжин дотоод нөөц боломжоо хэрэгжүүлэх ба өөрт шингэсэн мөн чанаруудаа бодит байдалд гаргана. Татвар хэмээх категорийг дурьдахад хүний ухамсарт эрх баригч төрийн зүг урсаж байгаа (өөрөөр хэлбэл хувийн хэрэглээнээс нийтийн хэрэглээ рүү) хөрөнгийн хөдөлгөөний төсөөлөл бууна. Энэ хөдөлгөөний утга агуулгыг ойлгохын тулд ямар учраас, яаж гарсан, юунаас олсон, ямар үр дүнд хүрсэн гэх зэрэг олон асуудалд харуулах болно. Энэ хөдөлгөөн бол амьдралын шаардлагаар урган гарсан, дахин хуваарилах харилцаа мөн болно. Иймээс татварын харилцааны үндсийг судлахдаа ниймийн үйлдвэрлэл буюу хуваарилалтын харилцааны зүй тогтлыг шинжлэх ухааны үүднээс шинжлэн үзэх хэрэгтэй болно. Татварын судалгаанд түүний дотоод мөн чанарт оршин байгаа дутагдалтай тал нь татварт ямар ч хамаагүй мөнгөн хөрөнгүүдийг албадан авах нийгмийн хандлага байдаг тул татварын болон татварын бус хэлбэрүүдийг ялгаж, танин мэдэх хэрэгтэй билээ.

Татварын тогтолцоо нь хамгийн боловсронгуй хэлбэрийг сонгон авсан ч гэсэн дотоод нөөц боломжийг үнэмлэхүй байдлаар танин мэдэж хэрэгжүүлэх боломж төдийлэн хангалттай биш байдаг. Иймээс татварын дотоод нөөц боломжийг авч үзэх нь нийгмийн нөөц баялагийн хөдөлгөөнийг тодорхой таниж мэдэх шаардлагатай байж болох юм. Өөрөөр хэлбэл хэдий хэмжээний нөөцтэй, ямар хэмжээний үйлдвэрлэл явуулсан гэх мэт. Бүтээсэн нийт баялагыг хуваарилах явцад татварын харилцаа үүснэ. Чухам ямар харилцаа вэ? гэдэг асуудал үүсэх ба үүнд санхүүгийн үүднээс хариулах болно. Хөрөнгө, орлого, хөдөлмөр, тодорхой үйлчилгээ зэрэг үйлдвэрлэлийн хүчин зүйлүүдийн бааз дээр татварт хамрах дахин хуваарилалтын харилцаа явагдана.

Мөн чанар ба агуулга, хийсвэр ба тодорхой, бодит ба субъектив, агуулга ба хэлбэр, шинжлэх ухаан ба практик энэ бүхэн бол оргоник нэг бүхэл зүйлийн салшгүй хэсэг, эдийн засгийн бодит орчинд татвар ногдуулалтын тогтолцоог бүрдүүлэн тогтоох шинжлэх ухааны хандлага.

"Татвар ногдуулалт (аргачлал, арга зүй) гэдэг нь татварын хэлбэрийг сонгон авч түүнийг тодорхой агуулгаар баяжуулан (татварыг тооцоолж төлүүлэх зохион байгуулалт, эрх зүйн журмыг бий болгох) татварын эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тогтооно гэсэн үг юм".¹ (стр. 11) гэж тодорхойлсон. Татвар ногдуулалтын үндэслэл нь:

- өмчийн хэлбэр өөрчлөгдөж байгааг илэрхийлнэ. Татвар нь хувийн өмчөөс улсын хэрэгцээнд шилжүүлэх хэсгийг албадан авах хэлбэр болдог.
- Татвар ногдуулах объект нь эдийн засгийн мөн чанарыг агуулсан тодорхой зүйл байна.
- Эдийн засгийн суурьтаа зохицсон, харьцангуй тэнцвэртэй байдлыг зохицуулагч байх ба өмчлөгчдийн эрхийг зөрчихгүй байна.
- Татвар ногдуулалтын замаар нийгэмчилсэн хөрөнгө нь гагцхүү нийт үндэстний хэрэгцээнд зарцуулагдах ёстой (зарим улс оронд үндсэн хуулиар хуульчлагдсан хатуу хяналтын доор зарцуулагддаг байна). Энэ үндэслэл нь татвар ногдуулалтын онолын нийтлэг чиглэлийг улам тодорхой болгох бөгөөд практикт хэлбэрэлтгүй мөрдөх ёстой байдаг байна.

Түүнчлэн дахин хуваарилалт хийгдэх татвар ногдуулах бодит үйл явцад дараах шаард-лагууд тавигддаг байна:

- Бодиттой бий болсон өртгийг л дахин хуваарилалтанд оруулна.
- Дахин хуваарилалтын эцсийн зорилго бол нийгмийн эрэлт хэрэгцээг аль болох дээд хэмжээгээр бүрэн дүүрэн хангах явдал юм.
- Дахин хуваарилалтыг аж ахуйн үйл ажиллагааны бүх хүрээнд чанарын төвшинг хэвээр байлгах төдийгүй дээшлүүлэх нөхцөлд хэрэгжүүлнэ.
- Өмчийн янз бүрийн хэлбэрийг тэнцвэртэй хөгжүүлэх, үйлдвэрлэлд оролцогч бүх талын

эрх ашгийн дагуу өрсөлдөх чадвартай эдийн засгийн орчин бий болгох зорилгоор лахин хуваарилалт хийнэ.¹ (стр. 39)

Татвар ногдуулалтын аргачлалын боловруулах нь татварын хэрэглэгдэж буй хэлбэрүүдийг шинжлэх ухааны онолын үндсэнд системтэй болгож, татвар ногдуулах, хураах механизмыг бүрдүүлсэн татвар төлөгч болон төрийн хооронд үүсч буй эрх зүйн харилцааны үзэл баримтлалын боловсронгуй бүтцийг бий болгоно гэсэн үг юм. Татварын эрх зүйн харилцааг боловсронгуй болгох үйл явц нь төгсгөлгүй бөгөөд онолын хувьд татварт агууллагадсан нөөц боломж нь бүрэн дүүрэн хэрэгжиж байх байдал руу дөхөж очно гэсэн үг юм. Энэ нөөц боломж хэрэгжих үндэс нь татварын сонгодог зарчмуудаар хэмжигдэнэ. Тухайлбал: татвар нь шударга, тэгш байх, нийгэмд үр ашигтай байх;

Татвар ногдуулалтын аргачлалын арга зүйн үндэс нь татварын механизм бөгөөд түүний элементүүд нь төлөвлөлт, зохицуулалт, хяналтаас бүрдэнэ. Философийн үүднээс татварын ойлголтын хүрээг нарийн зааглаж ойлгох нь татварт хандах хандлагыг бодит байдал руу чиглүүлнэ. "Татварын философи нь татварыг нийгмийн ухамсарлагдсан шаардлага хэмээх хүлээн авах тухай ертөнцийг үзэх үзлийн сургаал юм. Татвар ногдуулалтын онол нь нөхөн үйлдвэрлэлийн тухай эдийн засгийн онол, төр ба түүний үүргийн тухай онолын заалтыг үндэслэн татварын харилцааны арга зүйн үндсийг бүрдүүлж байгаа юм. Татварын философи ба татвар ногдуулалтын онолын нэгдэл нь шинжлэх ухааны салбар болох татвар судлалыг бий болгоно." (стр. 33) гэж тодорхойлсон.

Татвар хэмээх ухагдахууны гүн гүнзгий агуулгыг нь философийн үүднээс ойлгон мэдсэний дараа татвар ногдуулалтын аргачлалыг эзэмшинэ гэдэг нь мөн чанараараа ардчилсан шинжтэй бодит үнэнийг ойлгоно гэсэн үг юм. Татварыг нийгмийн сайн сайхан байлгах, хөгжлийн суурь үндэс нь мөн гэсэн ойлголттой болох нь аливаа иргэнд татвар төлөх ёстой гэсэн сэтгэлийг төлөвшүүлэх бөгөөд татварын онол, эрх зүйн үндэслэл, төрт ёсны хөгжлийн зүй тогтлыг судлаж мэдэх шаардлагатай юм.

А.Вагнер татвар ногдуулалтын зарчмуудыг боловсруулахдаа нэг талаас сонгодог чиглэлүүд, нөгөө талаас оновчтой байх тухай санхүүгийн төсөөллийг удирдлага болгосон. Тэрээр есөн үндсэн дүрэм боловсруулж түүнийгээ дөрвөн бүлэгт хуваан үзсэн байна.

1. Нийтийн эрэлт хэрэгцээний онолоор тодорхойлогдсон татвар ногдуулалт нь хүрэлцэхүйц ба уян хатан байх гэсэн зохион байгуулалтын зарчмууд
2. Татвар авах эх үүсвэрийг сонгох ба зөвхөн хувь хүнээс албан татвар авах ёстой юу гэдэг асуудлыг шийдвэрлэх
3. Татварт бүх нийтийг тогтмол хамруулах гэсэн ёс зүйн буюу шударга ёсны зарчмууд
4. Татвар ногдуулалт нь тодорхой байх, бодит боломжид тулгуурласан байх, татвар хураах зардал дээд зэргээр бага байх гэсэн татварын удирдлагын шинжтэй зарчмууд

Татварын харилцааг зохион байгуулах эдгээр зарчмууд нь татвар судлалын шинжлэх ухааны эхлэл гэж үзэх үндэстэй бөгөөд аль ч улсын татварын тогтолцоо дээрх зарчмуудад тулгуурладаг болон үндэсний эдийн засаг, төрт ёсны онцлогууддаа харгалзана.

Татвар ногдуулалтын харилцаа нь нийтийн эрэлт хэрэгцээнд үндэслэсэн улсын зардалтай шууд утгаараа холбоотой юм. Улсын зардлын бүтцийг оновчтой байлгах нь татвар ногдуулалтын үйл ажиллагааг үр дүнтэй хэлбэрт оруулах үндэс нь юм.

Дэлхийн улс орнуудын хөгжлийг хөгжингүй болон шинэ тулгар хөгжиж байгаа гэж ангилдаг шиг татварын тогтолцоо нь мөн шинэ тулгар хөгжиж байгаа шинж чанартай байж болох

бөгөөд хөгжлийн өндөр төвшинд байгаа улс орнуудын тогтсон татварын тогтолцоог шинэ тулгар хөгжиж байгаа улс орны төвшинд шууд хуулбарлан хэрэгжүүлэх нь нийгэм, эдийн засгийн суурьтайгаа нийцдэггүй буюу ямар ч үр нөлөөгүй зүйл болон хувирна. Тэгэхлээр татварын сонгодог зарчимд үндэслэн эдийн засаг, улс төрийн давхаргатайгаа нийцсэн үндэсний татварын үзэл баримтлалыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулж түүнд тохирсон татварын механизмыг бүрдүүлж хэрэгжүүлэх нь нийгмийн зайлшгүй шаардлага болоод байна. Яагаад гэвэл татвар гэдэг нь суурь талын ойлголт ба эдийн засгийн бааз суурь, өмчийн харилцаа, нийгмийн ухамсрын байдал, үйлдвэрлэл, иргэдийн эрх чөлөө гэх зэрэг нь янз бүрийн хүчин зүйлүүдээс хамаардаг буюу эдгээр нь улс орон бүрд ялгаатай байж болно. Нийгэм эдийн засгийнхаа нөхцөлд тохирсон татварын хэлбэрийг сонгож, хуульчлахгүй бол эдийн засагт нөхөж баршгүй хохирол учруулах буюу засаг захиргааны зүгээс арга хэмжээ аваад ч татварын орлогыг бүрэн дүүрэн хураан авч чадахгүйд хүрнэ. Энэ нь хууль тогтоомжийн санаачлага төдийхнөөр үлдэх ба татварын хуулиуд байнга өөрчлөгддөг тогтворгүй байдгийн шалтгаан нь юм.